



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/13

Өвт

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын Ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Үнэлгээний хорооны дарга: Н.Бат-Эрдэнэ-Засаг даргын Тамгын газрын дарга
- Гишүүд: -Н.Батжаргал-1 дүгээр Цэцэрлэгийн эрхлэгч
- Г.Болормаа-Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч
- Ч.Нандин-Эрдэнэ- Иргэний төлөөлөл
- Нарийн бичгийн дарга: Б.Ууганчимэг-Ерөнхий боловсролын сургуулийн Сургалтын менежер

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгийг хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Ууганчимэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН